

Гарчиг

1. Оршил
2. Ажил эрхлэлт, ажилгүйдэл, Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал
3. Шинэ ажлын байр
4. Ажиллагсадын дундаж цалин
5. Хавсралт хүснэгтүүд
6. Дүгнэлт
7. Ашигласан материал

ОРШИЛ

Хөдөлмөр эрхлэлт бол тухайн улс орны хамгийн чухал ах асуудлын нэг юм. Ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин нь тухайн орон нутгийн ядуурлын түвшин, эдийн засгийн үзүүлэлтийг тодорхойлох гол үзүүлэлт болдог.

Энэхүү судалгаагаар Дундговь аймгийн нийт хүн амын хэдэн хувь хөдөлмөрийн насныхан, тэдгээрийн хэд нь ажил хөдөлмөр эрхлэж байгаа, ажилгүйдлийн түвшин ямар хэмжээнд байгаа эсэх, хүн ам зүйн ачаалал, нийт хүн амын өсөлтөөс ажиллах хүчний өсөлт хэрхэн хамааралтай байгаа эсэх, аймагт аль салбарт шинээр ажлын байр голлон бий болж байгаа, ажиллагсадын дундаж цалин ямар хэмжээнд байгаа, цалингийн өсөлт хэрхэн өөрчлөгдөж байгаа зэрэг асуудлыг тусгахыг гол зорилгоо болголоо. Энэхүү танилцуулганы тоон мэдээллийг улсын хэмжээнд жил бүр явагддаг ажиллах хүчний түүвэр судалгааны тайлангаас авсан болно.

1. Ажил эрхлэлт, Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал

Дундговь аймаг 2013 оны жилийн эцсийн байдлаар 44400 хүн амтай болж өмнөх оноос 0,45 хувь буюу 201 хүнээр буурсан байна. Нийт хүн амын 22135 нь буюу 49.8 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Нийт хүн амын 67,0 хувь буюу 29733 хөдөлмөрийн насны хүн ам байгаа нь өмнөх оноос 63 хүнээр буурсан байна. Хөдөлмөрийн насны нийт хүн амын 49.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Нийт хүн амын 48,6 хувийг эдийн засгийн идэвхтэй хүн ам эзэлж байгаа нь өмнөх оноос 3,2 пунктээр буурсан байна. Нийт хүн амын 45,0 хувийг ажиллагсад эзэлж байгаа нь өнгөрсөн онд нийт шилжин явагсадын дунд эдийн засгийн идэвхитэй хүн ам, ажиллагсад их байгаа нь харагдаж байна. Мөн эдийн засгийн идэвхтэй хүн ам, ажиллагсад зэрэг үзүүлэлтүүд өмнөх оноос буурсан ба эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо өсчээ. Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо 9,2 мянгад хүрч өмнөх оноос 23,4 хувиар өсчээ. Эдийн засгийн идэвхтэй хүн амын 93,5 хувийг ажиллагсад эзэлж байна.

Хүн амын ажил эрхлэлтийн гол гол үзүүлэлтүүдийг сүүлийн 5 жилээр гаргаж дараах графикт үзүүллээ.

2013 оны байдлаар ажиллах хүчний оролцооны түвшин 72,7 хувь болж өмнөх оноос 6,1 пунктээр өссөн байна. Энэ нь хөдөлмөрийн насны нийт хүн амын 72,7 хувь нь эдийн засгийн идэвхитэй хүн байна гэсэн үг юм. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 93,5 хувь болж өмнөх оноос өссөн нь эдийн засгийн идэвхитэй хүн амд эзлэх ажиллагчдын тоо буураагүй нь харагдаж байна. Эдийн засгийн ачаалал 42,9 хувь байгаа нь эдийн засгийн идэвхитэй 100 хүн тутмын 43 нь эдийн засгийн идэвхгүй буюу ажил идэвхитэй хайх сонирхолгүй иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна гэсэн үг юм. Энэхүү үзүүлэлт өмнөх оноос 10,8 пунктээр өссөн нь эдийн засгийн идэвхигүй хүн ам 23,4 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн

тоо 1930 болж өмнөх оноос 0,9 хувиар өссөнтэй холбоотой юм. Ажиллах хүчний идэвхийн ерөнхий коэффициент 48,6 хувь болж өмнөх оноос 3,9 пунктээр буурсан нь нийт хүн амд эзлэх ажиллах хүчний тоо буурсан байгаа нь харагдаж байна.

Ажил эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд 2010-2013 он

Хөдөлмөрийн насны 100 хүн тутамд ноогдох эдийн засгийн идэвхигүй хүн ам 31,2 хувь болж өмнөх оноос 1758 хүн амаар буюу 23,4 хувиар өссөн нь эдийн засгийн идэвхигүй байдлын түвшин гэсэн үзүүлэлтээр харагдаж байна. Энэхүү үзүүлэлт сүүлийн жилүүдэд буурч байсан бөгөөд 2013 оны жилийн эцсийн байдлаар 31,2 болж өссөн нь харагдаж байна.

Хүн ам зүйн гол асуудлын нэг нь хүн ам зүйн ачаалал юм. Хүн ам зүйн ачаалал буюу хөдөлмөрийн насны 1 хүнд ногдох тэжээлгэгч хүний тоо сүүлийн 5 жилд тогтмол буурч 2013 онд 0,49 болсон байна. Хүн ам зүйн ачаалал өндөр байх нь үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүн амын амжиргааны төвшинг дээшлүүлэхэд сөрөг нөлөөтэй байдаг юм. Энэхүү үзүүлэлт тогтмол буурч байгаа нь нийт хүн амын дунд хөдөлмөрийн насныхан нэмэгдэж байгаатай шууд холбоотой байна.

ҮСХ-ноос зохион байгуулдаг Ажиллах хүчний түүвэр судалгаагаар 2013 оны эцсийн байдлаар ажилгүйдлийн түвшин 6.3 хувь болж өмнөх оноос 2,2 пунктээр буурсан бөгөөд энэ нь улсын дундажтай харьцуулахад 1.6 хувиар бага гарчээ.

Төвийн бүсийн бусад аймгуудтай харьцуулахад ажилгүйдлийн түвшингээрээ бага байгаа нь харагдаж байна.

**Ажил эрхлэлтийн түүвэр судалгаагаар тооцож гаргасан
ажилгүйдлийн түвшин /бүсээр болон бүсийн аймгуудтай
харьцуулсан байдлаар 2011-2013 он**

"Аймаг, нийслэл"	2011 он	2012 он	2013 он
Улсын дүн	7.7	8.2	7.9
Баруун бүс	10.8	9.8	11.9
Хангайн бүс	8.3	8.3	9.8
Төвийн бүс	6.8	7.7	7.7
Дорноговь	5.5	3.8	7.8
Дундговь	8.8	8.5	6.3
Өмнөговь	15.3	6.5	4.9
Сэлэнгэ	1.4	6.0	9.0
Төв	5.5	5.9	8.4
Дархан-Уул	8.4	14.3	8.1
Говьсүмбэр	4.8	6.1	6.2
Зүүн бүс	11.1	10.8	11.2
Улаанбаатар	5.6	7.1	4.6

Ажил эрхлэлтийн судалгаагаар гаргасан ажилгүйдлийн түвшингээс харахад төвийн бүсийн аймгуудын хувьд хамгийн өндөр үзүүлэлтэй аймаг нь Сэлэнгэ аймаг бөгөөд ажилгүйдлийн түвшин 9,0 болж улсын дундажаас 1,1 хувиар, төвийн бүсээс 1,3 хувиар өндөр байна. Дундговь аймгийн хувьд бүсийн бусад аймгуудтай харьцуулахад Өмнөговь,

Говьсүмбэр аймгуудаас 0,1-1,4 хувиар өндөр бусад аймгуудаас 1,4-2,7 хувиар бага байна. Сүүлийн 4 жилийн ажилгүйдлийн түвшинг 2010-2012 хүртэл улс бүсийн дундажтай харьцуулахад өндөр байсан бол 2013 оны эцэст 6,3 хувьд хүрч нилээд буурсан нь харагдаж байна.

Дундговь аймгийн хэмжээнд 2013 онд шинээр 730 ажлын байр бий болсон нь өнгөрсөн 2012 онтэй харьцуулахад 18,9 хувиар, 2010 онтэй харьцуулахад 39,2 хувиар буурсан байна. Нийт бий болсон ажлын байрны 22,5 хувь боловсруулах үйлдвэрийн салбарт гарч өмнөх оноос 5,7 пунктээр өссөн бол, хөдөө аж ахуйн салбарт нийт ажлын байрны 16 хувь бий болж өмнөх оноос 30 гаруй пунктээр буурсан байна. Төрийн удирдлага батлан хамгаалахын салбарт 9,7 хувь, уул уурхай олборлох үйлдвэрт 8,1 хувь, боловсролын салбарт 6 хувь нь бий болсон бол бусад салбарт 26 хувь нь бий болжээ.

Аойнаа	166	22.7
Ажаа	730	100.0

Адаацаг	30	27
Аүі	901	730

Шинээр бий болсон ажлын байрыг сум тус бүрээр авч үзвэл нийт ажлын байрны 38,6 хувь буюу 282 нь Сайнцагаан суманд, 9 хувь буюу 66 нь Хулд суманд, 6,6 хувь буюу 48 нь Сайхан-Овоо суманд, 7,4 хувь буюу 54 нь Дэрэн суманд байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна. 2013 онд Сайнцагаан сум 282 шинэ ажлын байр болгож өмнөх оноос 120 хувиар өссөн бол, Дэлгэрцогт сум 34 ажлын байр бий болгож өмнөх оноос 23 ажлын байраар өсгөсөн байна. Бусад 13 суманд шинэ ажлын байрны тоо буурсан байна.

3. Ажиллагсадын дундаж цалин

Хөдөлмөр эрхлэлт ажилгүйдэлтэй салшгүй холбоотой нэг гол асуудал бол хөдөлмөрийн хөлс юм. ҮСХорооноос гаргасан дундаж цалингийн судалгаагаар тус аймгийн хувьд 100 хүртлэх ажиллагсадтай аж ахуй нэгжийн цалин 590,0 төгрөг байгаа нь улсын дундажаас 6,3 хувиар бага байна. Харин 100 болон түүнээс дээш ажиллагсадтай аж ахуй нэгжийн дундаж цалин 754,6 мянга байгаа нь улсын дундажаас 58,4 мянган төгрөгөөр буюу 7,7 хувиар бага байна. Улсын хэмжээнд 100 –аас дээш ажиллагсадтай ААН-ын дундаж цалин 813,5 мянган төгрөг байгаа 100 хүртлэх ажиллагсадтай ААН-ын дундаж цалингаас 29,7 хувиар өндөр байна.

Ажиллагсадын дундаж цалинг аймаг тус бүрээр дараах хүснэгтэнд харууллаа. Эндээс үзэхэд Өмнөговь, Улаанбаатар, Говьсүмбэр аймгуудад 100 –аас дээш ажиллагсадтай аж ахуй нэгжийн цалин улсын дундажаас 3,8-44,5 хувиар өндөр байна. 100 хүртлэх ажиллагсадтай аж ахуй нэгжийн хувьд Улаан баатар хот 687,8 мянган төгрөг байгаа нь хамгийн өндөр байна.

**Ажиллах хүчний судалгаагаар тооцож гаргасан ажиллагсадын дундаж цалин
2013 он**

Аймаг	100 хүртэл ажиллагсадтай ААН-ын дундаж цалин	100-с дээш тооны ажиллагсадтай ААН-ын дундаж цалин
Улсын дундаж	627.2	813.5
Архангай	487.1	640.2
Баян-Өлгий	527.1	527.4
Баянхонгор	523.1	588.9
Булган	542.3	652.3

Говь-Алтай	497.6	701.4
Дорноговь	585	659.5
Дорнод	538.1	680.8
Дундговь	590	754.6
Завхан	570.1	650.8
Өвөрхангай	584.7	588.9
Өмнөговь	524.4	1,175.7
Сүхбаатар	564.1	648.8
Сэлэнгэ	468.4	695.8
Төв	497.3	610.7
Увс	500.5	611.6
Ховд	504.6	568.2
Хөвсгөл	532.1	642.6
Хэнтий	580.5	627.5
Дархан-Уул	547.6	687.1
Улаанбаатар	687.8	861.5
Орхон	522.3	711.9
Говьсүмбэр	434.8	844.3

4.Хавсралт хүснэгтүүд

4.1 Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох хөдөлмөрийн

чадваргүй хүн ам, сумдаар

Сумдууд

Хөдөлмөрийн насны хүн ам	Хөдөлмөрийн чадваргүй хүн ам	Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох хөдөлмөрийн чадваргүй хүн ам	
Дэлгэрцогт	9506	81	8.5
Дэрэн	1947	83	42.6
Говь--Угтаал	751	103	137.2
Цагаандэлгэр	1028	12	11.7
Баянжаргалан	1403	28	20.0
Өндөршил	1438	58	40.3
Гурвансайхан	1043	92	88.2
Өлзийт	1329	82	61.7
Хулд	1257	83	66.0
Луус	1544	110	71.2
Дэлгэрхангай	976	51	52.3
Сайхан-Овоо	1528	79	51.7
Эрдэнэдалай	1556	227	145.9
Сайнцагаан	660	669	1013.6
Адаацаг	3767	172	45.7
Аймгийн дүн	29733	1930	64.9

4.2 Ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд

Он	Нийт хүн амын тоо	Хөдөлмөрийн насны хүн ам	Ажиллах хүч	Ажиллагчдын тоо	Эдийн засгийн идэвхгүй хүн ам	Бүртгэлтэй ажилгүйдчүүд
2010 он	45.9	28.5	24.2	21.8	9224	848
2011 он	45.0	29.1	24.4	22.3	7455	638
2012 он	44.6	29.7	23.4	21.4	7514	828
2013 он	44.4	29.7	21.6	20.2	9272	829

Он	АХОТ	АХИЕК	ЭЗА	ХЭТ	Ат	ЭЗИБТ
2010 он	84.9	52.7	38.1	90.1	10.1	32.3
2011 он	83.8	54.2	30.6	91.4	8.8	25.6
2012 он	78.8	52.5	32.1	91.5	8.5	25.3
2013 он	72.7	48.6	42.9	93.5	6.3	31.2

АХОТ-Ажиллах хүчний оролцооны түвшин

АХИЕК-Ажиллах хүчний идэвхийн ерөнхий коэффициент

ЭЗА-Эдийн засгийн ачаалал

ХЭТ-Хөдөлмөр эрхлэлтийн түвшин

АТ-Ажилгүйдлийн түвшин

ÄĪ	29733	12396	2271	14667	416.9	183.2	493.3
----	-------	-------	------	-------	-------	-------	-------

4.5 Нийт хүн амд хөдөлмөрийн насны хүн ам, эмэгтэйчүүдийн эзлэх хувь

Сумд	Суурин хүн ам			Хөдөлмөрийн насны хүн ам			ХН-хүний суурин хүн амд эзлэх хувь	
	Бүгд	Эмэгтэй	Эмэгтэйн эзлэх хувь	Бүгд	Эмэгтэй	Эмэгтэйн эзлэх хувь	Бүгд	Эмэгтэй
Ñàéíààààí	13886	7155	51.5	9506	4985	52.4	68.5	69.7
Ààààòàà	2947	1456	49.4	1947	957	49.2	66.1	65.7
Ààÿíæàðààèàí	1180	563	47.7	751	365	48.6	63.6	64.8
Äíàü-Òàðààè	1532	764	49.9	1028	504	49.0	67.1	66.0
Äóðààííàéðàí	2111	1051	49.8	1403	686	48.9	66.5	65.3
Äÿèäÿððàíàè	2177	1072	49.2	1438	721	50.1	66.1	67.3
Äÿèäÿððàíàð	1547	758	49.0	1043	522	50.0	67.4	68.9
Äÿðÿí	2022	985	48.7	1329	652	49.1	65.7	66.2
Èóóñ	1892	910	48.1	1257	592	47.1	66.4	65.1
èççèéð	2233	1031	46.2	1544	697	45.1	69.1	67.6
àíà°ðøèè	1475	744	50.4	976	486	49.8	66.2	65.3
Ñàéðàí íàñ	2307	1119	48.5	1528	739	48.4	66.2	66.0
Òóèà	2347	1173	50.0	1556	755	48.5	66.3	64.4
Òààààíàÿèäÿð	979	469	47.9	660	304	46.1	67.4	64.8
Ýðàÿíÿàèèé	5765	2885	50.0	3767	1883	50.0	65.3	65.3
ÄĪ	44400	22135	49.9	29733	14848	49.9	67.0	67.1

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны мэдээллийн ҮСХорооноос жил бүр явагддаг ажиллах хүчний түүвэр судалгааны мэдээлэлд үндэслэн гаргалаа. Өнгөрсөн 2013 онд тус аймгийн хувьд хүн амын тоо, ажиллагсадын тоо, эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо буурсан үзүүлэлттэй, Эдийн засгийн идэвхигүй хүн амын тоо бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо өссөн жил болжээ. Ажиллах хүч буюу эдийн засгийн хүн амын тоо буурахад ажиллагсадын тоо шууд хамааралтайгаар буурч байна. Мөн ажилгүйчүүд хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлж ажил идэвхитэй хайх нь багассан нь эдийн засгийн идэвхигүй хүн амын тоо өсөхөд нөлөөлжээ. Эндээс үзэхэд нийт шилжин явагсадын дунд эдийн засгийн идэвхитэй хүн амын эзлэх хувь өндөр болсон байна. Шилжин явж байгаа иргэдийн урсгал ихэвчлэн Улаанбаатар, Говьсүмбэр, Өмнөговь аймгуудруу чиглэж байгаа иргэд ажил хайх хөдөлмөр эрхлэх зорилгоор явж байгаа нь харагдаж байна. 2011 оныг тус аймаг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан 2011 2012 онуудад шинэ ажлын байр жилд нэмэгдэж байсан бол 2013 онд өмнөх онуудаас буурч 730 ажлын байр бий болжээ.

Шинээр бий болж буй ажлын байрыг харвал боловсруулах үйлдвэр, барилгын салбар зэрэгт гарч байгаа ажлын байр өмнөх оноос өсчээ. Ажиллагсадын дундаж цалингийн хувьд улсын дундажаас 6,3-7,7 хувиар бага цалинтай байна.

Ашигласан материалууд

1. **Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний үзүүлэлтийг тооцох аргачлал, түүнийг ашиглах гарын авлага 2010 он**
2. **Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2009, 2010, 2011, 2012, 2013он**
3. **Хүн ам, орон сууцны тооллогын нэгдсэн дүн 2013 он**
4. **Статистикийн эмхтгэл 2013 он**
5. **Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгааны тайлан 2011-2013**
6. www.1212.mn
7. www.nso.mn

Танилцуулга бэлтгэсэн:

Мэргэжилтэн:

С.Доржханд

Хянасан:

Хэлтсийн дарга:

Н.Түвшинжаргал

Утас:

99256479

Факс

70593715

И-мэйл:

statistic_du@yahoo.com

Хаяг:

Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар

Дундговь аймгийн Статистикийн хэлтэс